



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын
нэрийг “Хамтын сонголт нам” болгож өөрчилсөн,
намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг болон
намын даргаар Б.Жагар сонгогдсоныг
бүртгүүлэх өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Хосбаяр даргалж, Танхимын тэргүүн Н.Баярмаа, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Н.Батчимэг, Э.Золзаяа, Ц.Оч, Т.Өсөхбаяр, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын нэрийг “Хамтын сонголт нам” болгож өөрчилсөн, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг болон намын даргаар Б.Жагар сонгогдсоныг бүртгүүлэх өргөдлийг шүүгч Д.Батбаатарын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын үүсгэн байгуулагч Б.Жагараас “Намын ээлжит бус Их хурал 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 74.5 хувийн ирцтэй хуралдаж, хурлын 26/04 дүгээр тогтоолоор намын оноосон нэр болох Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН) нэрийг “Хамтын сонголт нам” (ХСН) болгон өөрчлөхөөр, 26/05 дугаар тогтоолоор намын бэлгэдэл, далбааг шинэчлэн батлахаар, 26/06 дугаар тогтоолоор намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахаар, ... 26/07 дугаар тогтоолоор Б.Жагарыг намын даргаар сонгосныг тус тус бүртгүүлэх” тухай өргөдлийг 176 хуудас баримт, 1ш флаш, 2ш сонины хамт 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, материалыг Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба уг ажиллагааны явцад нэмэлт 13 хуудас баримт ирүүлснийг шалгаад нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын нэрийг “Хамтын сонголт нам” (ХСН) болгож өөрчилсөн

намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг болон намын даргаар Б.Жагар сонгогдсоныг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг. Хурлын процессын тухайд:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын дүрмийн 6.3-т “Намын Их Хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурлын шийдвэрээр тогтооно”, 6.4-т “Намын Их хурал нь 51 ба түүнээс дээш сондгой тооны сонгогдсон болон томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ”, 6.5-д “Энэхүү дүрмийн 6.4 дахь заалтад заасан төлөөлөгчдийн гуравны хоёроос багагүй төлөөлөгч хүрэлцэн ирснээр намын Их хурлыг хүчинтэйд тооцно”, 6.9.1-д “Намын даргын саналаар болон намын бага хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар намын ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулна”, 6.10-т “Намын ээлжит болон ээлжит бус Их хуралд аймаг, нийслэлийн намын хороодоос сонгогдсон төлөөлөгчдөөс гадна, намын Бага хурлын шийдвэрээр томилогдсон намын Бага хурлын гишүүд, гүйцэтгэх төв байгууллагын гишүүд, хяналтын хорооны гишүүд оролцоно”, 20.1.2-т “Их хурлын тов, байршил, хэлэлцэх асуудал, бусад холбогдох мэдээллийг энэхүү дүрэмд заасан хугацаанд намын гишүүдэд намын үндсэн фэйсбүүк пэйж хаяг болон намын гишүүд дэмжигчдийн группт нээлттэй нийтлэх, групп чатад зурвас оруулах, өдөр тутмын сонинд зар өгөх замаар мэдэгдэнэ” гэж тус тус заажээ.

Тус намын Бага хурал 9 гишүүнтэй бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд 8 гишүүн оролцон хуралдаж, 26/05 дугаар тогтоолоор ээлжит бус Их хурлыг 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хуралдуулахаар товыг тогтоож, төлөөлөгчдийн тоог 55 байхаар, тодруулбал нийслэлийн намын хорооноос 17 гишүүн, үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн, орон нутгийн намын хорооноос 21 ба түүнээс доошгүй төлөөлөгчдийг сонгох, албан тушаалын зарчмаар Дүрэм, ёс зүйн хорооны 5 гишүүн, Удирдах зөвлөлийн 4 гишүүн, Бага хурлын 9 гишүүнийг оролцуулахаар баталж, улмаар ээлжит бус Их хурлыг зохион байгуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Өргөдөлд хавсаргасан баримтуудаас үзвэл, дээрх ажлын хэсэг нь 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус Их хурлын зар болон хэлэлцэх асуудлын талаар намын гишүүдэд Өдрийн сонины 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн №082 (7934) дугаарт нийтлэн, мөн өдрийн “САИН нам” гэх фэйсбүүк хуудсаар дамжуулан хүргэсэн байх бөгөөд тус хуралд нийслэлийн намын хорооноос 17, Булган аймгийн намын хорооноос 5, Сүхбаатар, Өвөрхангай аймгийн намын хорооноос тус бүр 6, Хэнтий аймгийн намын хорооноос 3, албан тушаалын зарчмаар 18, нийт 55 төлөөлөгч оролцохоос 41 төлөөлөгч (эмэгтэй 43.9 хувь, эрэгтэй 56.1 хувь) оролцсон, энэ нь гуравны хоёроос дээш гишүүн оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдох ба жендерийн тэгш байдал хангагдсан, процессын хувьд зөрчилгүй байна.

Хоёр. Намын даргыг сонгосон тухайд:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... сонгоно” гэж;

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын дүрмийн 6.6.2-т “Намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах”-ыг намын Их хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх, мөн дүрмийн 8.2-т “Намын даргыг намын Их хурлаас 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох бөгөөд намын дарга дахин сонгогдож болно”, 8.6.2-т “Энэхүү дүрмийн 6.6, 6.9 дэх заалтыг баримталж намын даргад нэр дэвшигчийн хүсэлтийг хурал болохоос 10 хоногийн өмнө хүлээн авч нэр дэвшигчийг бүртгэж, нэр дэвшигчээр бүртгэсэн тухай бичгээр мэдэгддэг бөгөөд намын албан ёсны пэйж хуудаст хурал болохоос 5 хоногийн өмнө нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг байршуулна” гэж тус тус заажээ.

Тухайн намын ээлжит бус Их хурлыг зохион байгуулах ажлын хэсгээс дээр дурдсанаар намын фэйсбүүк хуудсаар дамжуулан намын даргад нэр дэвших хүсэлтэй намын гишүүдийг хүсэлт болон холбогдох материалыг 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн дотор ирүүлэх талаар зарлан мэдээлсэн. Намын даргын албан тушаалд Б.Жагар, Ц.Ганбат нар нэр дэвшиж, холбогдох материалыг ирүүлснийг тус ажлын хэсгийн 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 26/01 дүгээр тогтоолоор бүртгэж, эдгээр нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийг намын фэйсбүүк хуудаст нээлттэй байршуулсан байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын ээлжит бус Их хурлын 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар намын даргад нэр дэвшигч Б.Жагар, Ц.Ганбат нар өөрсдийн мөрийн хөтөлбөрийг танилцуулж, улмаар нууц санал хураалт явагдсан байх бөгөөд уг санал хураалтад нийт 41 төлөөлөгч оролцож санал өгснөөс хүчингүй санал-3, хүчинтэй-38 санал байна. Үүнээс: Бямбасүрэн овогтой Жагар - 29 төлөөлөгч буюу 76.32% санал, Цэсмаа овогтой Ганбат - 9 төлөөлөгч буюу 23.68% санал авчээ. Улмаар санал хураалтын дүнг үндэслэн ээлжит бус Их хурлын төлөөлөгчдийн 76.3 буюу олонхын санал авсан Бямбасүрэнгийн Жагарыг намын даргаар сонгосон болох нь мөн өдрийн Тооллогын комиссын 05 дугаар тогтоол, саналын хуудас, ээлжит бус Их хурлын 26/07 дугаар тогтоол, хурлын тэмдэглэл, видео бичлэг болон бусад баримтуудаар тогтоогдож байна.

Дээрх байдлаас үзэхэд, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын даргаар Б.Жагар сонгогдсон нь Улсын төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон намын дүрмийн холбогдох заалтуудад нийцсэн байх тул тус намын даргаар бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Гурав. Намын оноосон нэрийн өөрчлөлтийн тухайд:

Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Энэ хуулийн 16.1-д заасан байгууллагын болон намын бусад хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх, ...”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам нь оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ”, 6.2-т “Нам сонгуулийн сурталчилгаа болон бусад үйл ажиллагаанд зөвхөн намын бүртгэлд бүртгүүлсэн бүтэн болон товчилсон нэрийг хэрэглэнэ”, 6.4-т “Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй”, мөн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:”

гээд 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах”, 17.2.3-т “намын нэрийг өөрчлөх, ...” гэж;

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын шинэчилсэн дүрмийн 1.5.7-д “Намын аливаа асуудлыг ил тод, ардчиллын зарчмаар хэлэлцэн олонхын саналаар намын дүрэм болон холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэх ...”, 1.7-д “Намын их хурал, Төлөөллийн төв байгууллага, Гүйцэтгэх төв байгууллага, Хяналтын хороо болон бусад намын бүтцийн бүх шатны байгууллага нь хуралдаанаараа аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхдээ хуралд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ”, 6.5-д Энэхүү дүрмийн 6.4 дахь заалтад заасан төлөөлөгчдийн гуравны хоёроос багагүй төлөөлөгч хүрэлцэн ирснээр намын Их хурлыг хүчинтэйд тооцно”, 6.6-д “Намын Их хурал нь бодлогын үндсэн асуудлыг хэлэлцэн, онцгой бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэнэ”, 6.6.6-д “Намын нэрийг өөрчлөх”, 6.6.7-д “Намын бэлгэдлийг батлах, өөрчлөх”, 6.6.13. Энэхүү дүрмийн 6.6.1, 6.6.3, 6.6.6, 6.6.7, 6.6.8, 6.6.9-д тус тус заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ илээр санал хурааж олонхын саналаар шийдвэрлэнэ” гэж тус тус заажээ.

Мөн Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 9.1-д “Дараах тохиолдолд улс төрийн намын нэр авах хүсэлтийг Бүртгэлийн албанд гаргаж, тухайн нэрийн баталгаажуулалт хийлгэнэ.” гээд 9.1.2-т “намын нэрийг өөрчлөх”, 9.2-т “Хүсэлтэд дурдсан нэр нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй бусад намын нэр болон өөр бусад хуулийн этгээдийн нэртэй давхцаагүй бол нэрийн баталгаажилт хийнэ...”, 9.3-т “Энэ журамд заасны дагуу баталгаажсан намын нэр 30 хоногийн дотор хүчинтэй байна. Өргөдөл гаргагчийн хүсэлтээр уг хугацааг 60 хоногоор сунгаж болно” гэж заасан.

Хувийн хэрэгт авагдсан болон өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаар, тухайн намын үүсгэн байгуулагч Б.Жагараас 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр “Хамтын сонголт нам” нэрийн баталгаажуулалт авах хүсэлт гаргасан, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 05/1049 дугаартай албан бичгээр нэрийн давхцал байгаа эсэхийг тодруулахаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандсан бөгөөд тус газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 5/3265 дугаар албан бичгээр “Хамтын сонголт нам” (ХСН) нэртэй ижил, төсөөтэй хуулийн этгээд улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлгүй” талаар хариуг ирүүлсэн, үүний дагуу тус намд “Хамтын сонголт нам” нэрийн баталгаажуулалт олгож, улмаар хүсэлтийг үндэслэн 2026 оны 07 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл сунгасан нь хүчинтэй байна.

Тус намын 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус Их хуралд 41 төлөөлөгч оролцож, 100 хувийн саналаар намын оноосон нэрийг “Хамтын сонголт нам”, товчилсон нэрийг (ХСН) болгож өөрчлөн баталсан бөгөөд уг өөрчлөлттэй холбогдуулан намын дүрэмд “Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам” гэсэн нэрийг “Хамтын сонголт нам” гэж нэрийн өөрчлөлтийг оруулж, улмаар 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн ээлжит бус Их хурлын “намын оноосон нэр өөрчлөгдсөнийг батлах тухай” 26/04 дүгээр, “Намын бэлгэдэл, далбаанд өөрчлөлт оруулах тухай” 26/05 дугаар, “Намын оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 26/06 дугаар, Тооллогын комиссын 02, 03, 04 дүгээр

тогтоолыг тус тус гаргасан болох нь өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаар тогтоогдож байна.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын ээлжит бус Их хурлын 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хурлын тэмдэглэлд намын нэрийг өөрчлөх болсон үндэслэл шалтгааныг "... ардчилсан нийгэмд иргэдийн оролцоо, хамтын шийдвэр гаргалт, нийгмийн зөвшилцөл, тэгш боломжийн зарчмыг илэрхийлсэн утга агуулгатай болно. "Хамтын" гэх ойлголт нь нийгмийн бүлгүүдийн эв нэгдэл, харилцан хүндэтгэл, нийтийн эрх ашгийг дээдлэх, хамтын хариуцлагад суурилсан хөгжлийн үзэл санааг илэрхийлдэг. Энэ нь социал демократ үзэл баримтлалын үндсэн үнэт зүйл болох нийгмийн эв санааны нэгдэл, шударга ёс, тэгш боломжийг хангах зарчимтай нийцнэ. "Сонголт" гэх ойлголт нь хүний эрх, эрх чөлөө, ардчилсан оролцоо, олон ургальч үзэл, иргэд өөрсдийн ирээдүйг чөлөөтэй тодорхойлох эрхийг илэрхийлнэ. Энэ нь социал демократ үзлийн ардчиллыг дээдлэх, хүний эрхийг хамгаалах, иргэдийн оролцоонд тулгуурласан төрийн бодлогын үзэл санаатай нийцэж байна. Иймд, Хамтын сонголт гэх нэр нь: ардчилсан үнэт зүйлсийг хамгаалах, нийгмийн шударга ёсыг бэхжүүлэх, иргэн бүрт тэгш боломж олгох, хамтын оролцоо, зөвшилцөлд тулгуурласан хөгжлийг дэмжих, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэх социал демократ үзэл баримтлалын агуулгыг илэрхийлсэн нэр болно. Түүнчлэн энэхүү нэр нь Монгол Улсын Үндсэн хуулийн ардчилал, шударга ёс, хүний эрх, иргэдийн оролцооны суурь зарчимд нийцсэн агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд нийгмийн тодорхой нэг бүлгийн ашиг сонирхлыг бус нийт иргэдийн хамтын эрх ашиг, нийтлэг хөгжлийн үзэл санааг төлөөлсөн нэр томъёо юм" гэж тодорхойлсон байна.

Дээрх байдлаас үзэхэд, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын ээлжит бус Их хурлын 2026 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 26/04 дүгээр тогтоолоор Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИН)-ын нэрийг "Хамтын сонголт нам" (ХСН) болгон өөрчилж, уг өөрчлөлттэй холбогдуулан намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан нь хууль болон дүрмийн дээрх заалттай нийцсэн байна.

Намын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Өдрийн сонины 2026 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн №092 (7944) дугаарт намын нэрийг "Хамтын сонголт нам" (ХСН) гэж өөрчилснийг зарлуулсан зар, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт зэрэг шаардагдах бусад баримтыг хавсаргасан болохыг дурдав.

Энэхүү Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын оноосон болон товчилсон нэрийг "Хамтын сонголт нам" (ХСН) болгон өөрчилж, уг өөрчлөлттэй холбогдуулан намын дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг оруулж шийдвэрлэснийг, мөн тус намын даргаар Б.Жагар сонгогдсоныг бүртгэж шийдвэрлэлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 16¹ дүгээр зүйлийн 16¹.1.2 дахь заалтад заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.3-т заасныг тус тус баримтлан Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам

(САИН)-ын нэрийг “Хамтын сонголт нам” (ХСН) гэж өөрчлөн, уг өөрчлөлттэй холбогдуулан намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсныг тус тус бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д заасныг баримтлан тус намын даргаар Бямбасүрэнгийн Жагарыг бүртгэсүгэй.

3.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ХОСБАЯР

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР